



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 0/367

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.8 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 113 дугаар тусгай салбарын аюулгүй байдлыг хангасан блокон хашаа барих зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг, Хилийн Цэргийн 0131 дүгээр ангийн 0110 дугаар тусгай салбарын цэргийн байрыг цэвэр усны төвлөрсөн шугамд холбох зардалд 5,257,600 (таван сая хоёр зуун тавин долоон мянга зургаан зуу) төгрөг, нийт 8,257,600 (найман сая хоёр зуун тавин долоон мянга зургаан зуу) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх 8,257,600 (найман сая хоёр зуун тавин долоон мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100819